



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

VIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордонд 72.5 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Халдварын цар тахлын нөхцөл байдал, өсөлтийн шалтгаан цар тахлыг бууруулах арга хэмжээний санал, нөөц хангалтын байдлын мэдээлэл;

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

2. Улаанбаатар хотод халдварт цар тахлыг хумих, орон нутагт халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хотоос орох, гарах хөдөлгөөн үзвэр үйлчилгээ, зарим үйлчилгээний газруудын үйл ажиллагааг түр зогсоох зохицуулалт хийх тухай;

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар

3. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх танилцуулга мэдээлэл;

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНААС ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд,

Нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

1.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын заасны дагуу нийслэлийн хэмжээнд “Улбар шар түвшинд” шилжүүлж, хязгаарлалтаас хамаарах шаардлагыг хэрэгжүүлэх;

1.2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг хумих, хөдөө орон нутагт халдвар гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлээс гарах хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоох;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүд,

Агентлагийн дарга,

Нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

2.1. Нийслэл хотод халдварын эрсдэл өндөр байгаатай холбогдуулан төрийн байгууллагын ажилтан /иргэдэд үйлчлэх байгууллагууд тусгай дэглэмээр/ албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулах, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх;

2.2. Төрийн болон нутгийн удирдлага, захиргааны байгууллага хуулийн этгээдэд ажилладаг 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг, эхийг гэрээр ажиллах боломжоор хангаж, цалинтай чөлөө олгох;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүд,

Агентлагийн дарга нарт,

3.1. Хурал, цуглаан олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахдаа нэг дор 10-аас илүү хүн цуглуулахгүй байхаар хязгаарлалт тогтоож, мөрдүүлэх;

Дөрөв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзориг

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сүмъяабазар нарт

4.1. Вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлж, вакцинжуулалтад иргэдийг хамруулах хуваарь, төлөвлөгөөг гаргах, цэгийн тоог нэмэгдүүлэх, орон нутгаас вакцинжуулалтын ажилд эмч, мэргэжилтнүүдийг татан оролцуулж, сургаж бэлтгэх арга хэмжээ авах, вакцинжуулалтын талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээллэх;

Тав. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ,

Тагнуулын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа П.Одонбаатар,

Харилцаа холбооны зохицуулах түр хорооны дарга Г.Чинзориг,
Шуурхай штабын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэн нарт

5.1. Улсын онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, мэдээллийн нэгдсэн програм, системтэй болгох, бүх шатны шуурхай штаб, холбогдох байгууллагууд мэдээлэл шуурхай солилцох техник технологийн нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлыг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ажиллагаанд оруулж хэвшүүлэх;

Зургаа. Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа,
Улсын онцгой комиссын гишүүн Ж.Болд нарт,

6.1. Халдварт цар тахлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хот доторх хүн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарлах /эмнэлгийн тусламж үйлчилгээ, буяны ажил, шөнийн нислэг, инженер хангамжийн ажил, тусгай зориулалтын техник хэрэгслээс бусад/;

6.2. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг зах худалдааны төвүүдийн халдвар хамгааллыг сайжруулах, ажиллах өдөр цагийн хуваарьт зохицуулалт хийх;

Долоо. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболдод

7.1. Хөдөө орон нутагт түргэвчилсэн оношлуурын нөөцийг бүрдүүлж, 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор худалдан авах үйл ажиллагааг төсвийн болон бусад санхүүгийн эх үүсвэрээр шийдвэрлэн зохион байгуулах;

Найм . Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,
Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа,

Улсын онцгой комиссын гишүүн Ж.Болд нарт,

8.1. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан иргэн хуулийн этгээдэд тавих хяналтыг сайжруулж, хэрэг зөрчилд тооцох хариуцлага, хяналтыг нэмэгдүүлж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын үр дүнг өдөр бүр мэдээлж ажиллах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Ж.АМГАЛАН

